

ТООН МЭДЭЭЛЭЛ

#1	2012, 2013 оны шилдэг даатгагч	108	Нийт ажиллагсдын тоо	22	Үйл ажиллагаа явуулсан жил
#2	2015 онд ЖД -ын хохирол төлөлтийн харьцаа үзүүлэлт	25	Салбар төлөөлөгчийн газар	10%	Зах зээлд эзлэх хувь
#3	2015 онд хохирол төлөлтийн харьцаа үзүүлэлт	375	Төлөөлөгчдийн тоо	70,000	Даатгуулагчдын тоо

БИДНИЙ ТУХАЙ

Ард Даатгал компани нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, Монгол улсыг бүхэлд нь хамарсан 25 салбар, 370 гаруй төлөөлөгчидтэй, 100 гаруй ажиллагсадтай даатгалын компани болж өргөжин 22 дахь жилдээ даатгалын үйлчилгээ үзүүлэн үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулж байна.

Ард Даатгал компани нь харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж, даатгалын зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэн, өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглон, эрх зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөн, зүй бус хэлцэлд оролцохоос татгалзаж, үйл ажиллагаандаа нээлттэй, шударга, ёс зүйг баримталж ажилладаг.

Даатгагчийн харилцагч байгууллага, даатгуулагч нарынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадамжийг илэрхийлдэг гол үзүүлэлт болох төлбөрийн чадварын үзүүлэлт нь тус компанийн хувьд СЗХ-ны 2013 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам"-ын тооцоолоор зохих түвшинд байна.

ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР, ДАВХАР ДААТГАЛ (САЯ ТӨГ)

	2012	2013	2014	2015
ХУРААМЖ	8,520	10,094	10,106	9,160
НӨХӨН ТӨЛБӨР	1,761	2,557	3,095	3,829
ДАВХАР ДААТГАЛ	3,005	4,234	1,816	1,842

ЗАРДЛЫН ХАРЬЦАА & ХОХИРЛЫН ХАРЬЦАА

	2012	2013	2014	2015
ЗАРДЛЫН ХАРЬЦАА	0.57	0.54	0.57	0.59
ХОХИРЛЫН ХАРЬЦАА	0.38	0.41	0.41	0.59

НИЙТ ХӨРӨНГӨ & НӨӨЦ САН (САЯ ТӨГ)

	2012	2013	2014	2015
НИЙТ ХӨРӨНГӨ	6,345	7,128	8,689	8,759
НӨӨЦ САН	3,380	3,240	4,163	4,532

	ДААТГУУЛАГЧИЙН ТОО	НӨХӨН ТӨЛБӨР АВСАН ДААТГУУЛАГЧИЙН ТОО	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ДҮН (САЯ ТӨГ)
2015	70,583	6,685	3,829
2014	61,133	6,134	3,095


ДААТГАЛЫН БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ

ДААТГАЛЫН ХЭЛБЭР	ХУРААМЖ (САЯ ТӨГ)				НӨХӨН ТӨЛБӨР (САЯ ТӨГ)			
	2014		2015		2014		2015	
ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГА	2,049	20.3%	2,294	25.1%	1,305	42.1%	1,712	44.6%
ХӨРӨНГӨ	1,935	19.1%	2,925	31.9%	373	12.1%	267	7.0%
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	1,686	16.7%	1,230	13.4%	890	28.8%	823	21.5%
АГААРЫН ХӨЛӨГ	1,526	15.1%	1,128	12.3%				
САНХҮҮ	892	8.8%	22	0.2%	110	3.6%	528	13.8%
ГЭНЭТИЙН ОСОЛ, ЭРҮҮЛ МЭНД	585	5.8%	441	4.8%	282	9.1%	335	8.8%
ХАРИУЦЛАГА	583	5.8%	612	6.7%	63	2.0%	48	1.3%
БАРИЛГА УГСРАЛТЫН	484	4.8%	209	2.3%			6	0.2%
АЧАА ТЭЭВЭР	366	3.6%	299	3.3%	72	2.3%	108	2.8%
НИЙТ	10,106	100%	9,159	100%	3,095	100%	3,829	100%

ТҮҮХЭН ЗАМНАЛ

- 2015** Даатгалын цахим мэдээллийн сантай болов.
- 2014** Ард Санхүүгийн Нэгдэл ХХК хөрөнгө оруулагч болов.
- 2013** Монгол улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал "Хөх дэвтэр" гардав.
- 2013** МХАҮТ-ын шалгаруулалтаар "Оны шилдэг даатгалын компани" болов.
- 2012** Grand Expo -ийн "Оны шилдэг даатгалын компани" болов.
- 2011** Гранд Даатгал ХХК -ийг өөртөө нэгтгэв.
- 2010** "International Quality Era Award" (Switzerland, Geneva) шагнал гардав.
- 2008** СЗХ-ны "Оны шилдэг даатгалын компани" болов.
- 2004** Их Британийн "Omni Whittington Group" хөрөнгө оруулагч болов.
- 2000** Монгол улсын "ТОП-5" даатгалын компанийн нэг болов.
- 1994** Ард Даатгал ХХК үүсгэн байгуулагдав.

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД



ДАВХАР ДААТГАЛ

Ард Даатгал компани нь давхар даатгалын үйл ажиллагааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, СЗХ-ны дүрэм, журамтай нийцүүлэн Олон Улсад мөрдөгддөг хэм хэмжээний дагуу явуулдаг ба энэ талаар 20 гаруй жилийн турш ихээхэн туршлага хуримтлуулсан бөгөөд Олон Улсын давхар даатгалын зах зээлд нэр хүндтэй дотоодын даатгагч болжээ.

Дэлхийн томоохон давхар даагчийн нэг болох ХБНГУ-д төвтэй Европын Холбооны хамгийн том даатгалын групп Allianz нь Ард Даатгал компанийг Монгол дахь стратегийн түншээр албан ёсоор сонгож ажиллаж байна.

Шууд даатгагчийн хувьд бид ихэвчлэн барилга угсралтын ажил, агаарын хөлөг, хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал, гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын хэлбэрүүдээр өндөр даатгалын үнэлгээтэй гэрээнүүдийг давхар даатгуулж байна.

Бид даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн хариуцлагаа бүтнээр болон хэсэгчлэн нэр хүнд бүхий давхар даатгалын брокеруудаар дамжуулан олон улсын даатгалын (ихэвчлэн Лондон, Сингапур, Хонг Конг, ОХУ) зах зээл дээр давхар даагч нарт даатгалын гэрээг баталгаатай, бодит үнээр, түргэн шуурхай борлуулан, хамгаалалт олж авдаг. Түүнчлэн гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Ингострах болон Францын Европ ассистанс компанитай хамтран гадаадад аялагчдын иж бүрэн даатгалын үйлчилгээг санал болгож байна.

Бидний харилцдаг давхар даагчид нь үнэлгээ хийж, зэрэглэл тогтоодог эрх бүхий S&P, A.M. Best Company зэрэг байгууллагуудаас өндөр зэрэглэл авсан олон жилийн түүхтэй, олон улсын даатгалын зах зээл дээр нэр хүндтэй давхар даагч нар байдаг юм. (Жич: Hannover Re, (Standard & Poor's AA- "Very Strong" A.M. Best A+ "Superior") гэх мэт)

Манай гэрээнд түгээмэл оролцож буй давхар даагч нарын заримыг дурдвал Munich Re, Swiss Re, Hannover Re, Lloyd's syndicates, Chartis, ACR, Kiln, Allianz AIG Europe, Zurich Re, Royal & Sun Alliance, AWAC, Tokio Marine Europe, Unity Re, Ингострах, Russian Re, PICC, China Re, Best Re, Mapfre, Beazley Singapore, мөн давхар даатгалын зарим брокеруудыг дурдвал: AON, Marsh, Willis, UIB, JB Boda, Faber, Malakut гэх мэт компаниуд болно.

Ард Даатгал компанийн давхар даатгалын гэрээнүүд нь факультатив, гэрээт болон фронтингийн гэрээний төрлүүдээр хийгдэж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Ард Даатгал компани нь ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сайн дурын болон албан журмын төрөл бүхий 50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна. Мөн "Жолоочийн даатгалын тухай" хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжүүлэгч даатгалын ууган компаниудын нэг юм.

